

XX ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН УРАН ЗОХИОЛЫН ӨВӨРМӨЦ ШИНЖИЙГ СУДЛАХ АСУУДАЛД

Хөхмандал, магистр, МУИС

Abstract

As a results of social-economic, politics, histories the development of literature in Mongolian culture from the ancient time on, has developed into three main directions, and they are all different from each other at this developing period in the 20th century.

The aim of the research is comparison on traits among Mongolian literature of Halah Mongol, Inner Mongol and Oirad Mongol. Firstly, the cultural similarity of Mongolian literature among Halah Mongol, Inner Mongol and Oirad Mongol were concluded and conceptualized; Secondly, the cultural uniqueness of Mongolian literature among Halah Mongol, Inner Mongol and Oirad Mongol were clarified.

Based on the research, we can reach the following conclusion. Therein:

-Even though in ancient time had grown up from one root and soil of development of Mongolian literature to the 20th century, that is separated into at least three major direction when we reached by being relatively different feature due to including socioeconomics, politics and history.

-However, they developed differently, the traits of the separated development patterns are common in several factor at 20th century. In the scope special emphasis on the main culture, language and mentality, social-history etc. conditions.

Literature of Mongolian ,Inner Mongolian, Oirad Mongolian have been developing differently due to the other history-culture, mentality and the influence of other national culture etc.

Түлхүүр үг

Соёлын нийтлэг шинж, сэтгэлгээ, хэл сэтгэхүйн нэгдэл, Монголчуудын утга зохиол, Монгол туургатны соёл

Удиртгал

Тус судалгааны өгүүлэлд Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолын онцлогийг харьцуулан дүгнэлт хийхийг зорьсон юм. Тус зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан билээ. Үүнд:

Нэгдүгээрт: Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолын соёлын нийтлэг шинжийг нэгтгэн томъёолох,

Хоёрдугаарт: Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолын соёлын өвөрмөц хандлагыг тодруулан судлахад оршино.

Судалгаанд утга зохиол судлалын болон соёл судлалын онол, арга зүйн үндсийг удирдлага болгон ашигласан болно. Энэхүү өгүүлэлд уг чиглэлээр судалгаа хийсэн эрдэмтэн судлаачдын бүтээлүүд болон эх зохиолуудыг үндсэн хэрэглэгдэхүүн болгон хэрэглэж байна.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн их өөрчлөлт шинэчлэл, хувьсал хөгжлийг авчирсан XX зуун нь Монголын утга соёлын амьдралыг шинэ эргэлтэд оруулсан байна. Сүүлийн зуу гаруй жилийн түүхэнд гарсан удаа дараагийн хувьсгалын үр нөлөөгөөр Монгол оронд үндэсний ардчилсан болон социалист үзэл санаа түгэн дэлгэрч, улмаар ардчилсан нийгмийн давалгааг үүсгэн, зөвхөн утга зохиолын төдийгүй нийт

нийгмийн амьдралд түүхийн шинэ хуудсуудыг нээж өгсөн билээ. Мөн энэ түүхэн цаг үеийн эхээр БНХАУ-ын нөлөөнд Өвөрмонгол, Ойрад нутгийн ард иргэд орсноор харилцан адилгүй амьдралын хэвшил, уран зохиолын хөгжлийн өөр хандлагыг бий болгосон билээ. Ийнхүү нийгэм-түүхийн агуу хувьсгал нь хүмүүний соёлын, түүний дундаас Монгол үндэстний утга зохиолын амьдралын хувьслын суурь болсон гэж үзэж болно. Хил залгаа боловч өөр өөр улс гүрний нөлөөнд хөгжин дэвшсэн Монголчуудын утга соёл, уран зохиол нь өөр өөрсдийн онцлогийг шингээн хөгжиж ирсэн байна. XX зууны Монголын уран зохиол нь хөгжлийн өнгөрсөн хугацаанд газар зүйн байрлал, ард түмний зан заншил, нутгийн аялгуу, соёл уламжлал хийгээд гаднын соёлын нөлөөлөл зэргээс шалтгаалж онцлог талуудыг шингээн бүрэлдэн бий болжээ. Тухайлбал, Халх, Өвөрмонгол, Ойрад, Буриад, Халимаг уран зохиол гэх мэтээр өөр өөрсдийн онцлог хэв шинжийг нэгэнт олжээ.

Тиймээс “Соёл бол үндэстний шинж тэмдэг мөн” (张文勋, 1998, х.3) гэдэгчлэн уран зохиол бол үндэстний соёлын толь нь болж өгдөг билээ. Эрт цагаас Монгол соёлын хөрсөн дээр соёлон ургасан уран зохиол нь XX зууныг хүртэл

нэгдмэл цогц тогтолцоотой байжээ. Иймд Монгол туургатны уран зохиолын асуудлыг нэгтгэн судлах, харьцуулан шинжлэх, системчлэн дүгнэх нь зайлшгүй юм.

Нэг. Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолын нийтлэг үндэс

1.1. Соёлын нийтлэг шинж

“Аливаа үндэстний соёлын өв уран зохиолоор дамжин уламжилж, хадгалагдан хөгжихийн сацуу уран сайхны сэтгэлгээ нь бодит зүй тогтлын дагуу хөгжиж байдаг билээ. Тэрхүү зүй тогтол нь зохиолчдын бүтээл туурвилын уламжлал шинэчлэлээр илрэлээ олдог.” (Д.Цэдэв, 1986, х.1) Тухайн цаг үеийн утга зохиол нь нийгмийн амьдралын бодит хэрэгцээнээс үүсэж, өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн гурван цагийн үзэл санааны залгамж холбоон дээр бүрэлдэж хөгждөг билээ. “Утга зохиолын шинэ өнгө аяс улиран хуучирч хойч үеийн хүмүүстээ уламжлагдан хэрэглэгдэж үеэс үед залгамжилсны үндсэн дээр шинэ утга зохиолын өнгө бүрэлдэн буй болдог.” (Хасгоо, 1998, х.403) Энэ нь уран зохиолын уламжлал шинэчлэлийн жам ёс болно. Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиол нь эртнээс Монгол аман болон бичгийн зохиолоос урган гарсан гурвалсан урсгал бөгөөд Монголчуудын язгуур соёл, зан заншилд гүн шингэсэн байдаг.

Үндэстэн бий болж бүрэлдэн хөгжих явцдаа өөрийн соёлыг бий болгож байдаг бөгөөд аливаа үндэстэн нь байгаль, нийгмийн харилцан шүтэлцээнд бүрэлдэн оршин тогтнодог. (张文勋, 1998, х.13) Соёлоо хадгалан, уламжлан үлдээж улмаар батжуулж байх нь тухайн үндэстний оршин тогтнохын нэг чухал баталгаа болно. Үндэстний соёлын дотоод цөм нь үндэстний шинж” (张文勋, 1998, х.126) болох учраас тэрхүү соёлын агуулга нь үндэстний шинжийн тод илрэл юм. Соёлын агуулга нь үндэстний соёлын шинж тэмдгийг дээд хэмжээгээр хураангуйлж хийсвэржүүлж гаргадаг тул дараа нь хэзээд баялаг агуулагдахуунтай бэлгэдэлт шинж бүхий ухагдахуунаар тодрон гардаг билээ.

Энэхүү үзэл баримтлалын үүднээс Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолыг ажиглахад бүгд Монгол соёлын илэрхийлэл, Монгол уран зохиолын залгамж, үндэстний үзэл санааны тод тусгал буюу хураангуйлал мэт байна. Тэдгээр зохиолд туссан нийгмийн амьдрал, ард түмэн, зан заншил, үзэл суртал, хийморь сүлд, хувь тавилан, баяр гуниг, хүсэл зоригийн илэрхийлэл нь Монгол соёлын хэв маяг хийгээд Монгол уран зохиолын уламжлалын онцлогийг тодорхой харагдуулна. Жишээлбэл, Монголын өндөрлөгөөс үүсэн дэлгэрсэн нүүдэллэн амьдрах ахуй нь

байгальтайгаа зохицсон байсан хэдий ч нүүж суух, байгалийн гамшгаас мал сүрэг, амь биеэ хамгаалах хатуужил зориг тэвчээрийг шаардсан байдаг. Иймээс Монголчуудын сэтгэлгээнд хүч чадалтай баатарлаг эрс төсөөлөгдөн байх нь тодорхой юм.

Энэхүү байгаль газар зүйн тогтоц, нүүдлийн иргэншил, мал аж ахуйн соёлын онцлогоос урган гарсан «баатар шүтлэг» ба гоо сайхны эрмэлзэл нь монгол уран зохиолын нэгэн гол сэдэв болсоор иржээ. Домог, шидэт үлгэрээс баатарлаг тууль, “Нууц товчоо”, “Хөх судар” мөн цаашилбал орчин үеийн уран зохиол дахь “Тунгалаг тамир”, “Цаг төрийн үймээн”, Өвөрмонголын уран зохиол дахь “Саруул нутаг”, “Морьт цэргийн дуулал”, “Дэлгэр хангай”, “Засгийн хотгор”, “Намартаа сэрүүн баарин”, “Хорчины босогчдын дуу”, Ойрадын уран зохиол дахь “Таригтай Гончигийн үлгэр”, “Таригтай шинжийн үлгэр” зэрэг зохиол бүтээлүүдэд домог, шидэт үлгэрийн ид шидэт баатраас туулийн баатар - түүхэн баатрууд - Хорчины босогчид - хувьсгалт баатрууд - шилийн сайн эрс - Хорчины “шилийн сайн эр”-ийн дүрүүд төгс бүтсэн байдаг. Эдгээр дүрүүдийн үзэл санааны гол чиг шугам нь түүхэн цаг үеийн хэрэгцээ шаардлагаар хувирч хөгжиж ирсэн баатар эрсийн дүрүүд юм. Монголчуудын сэтгэлгээнд нэвт шингэсэн энэхүү үе үеийн онцлогийг хадгалсан баатар сайн эрсийн төсөөлөл нь Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолд адил төстэйгөөр шингэсэн байдаг нь туурга нэгт монголчуудын сэтгэлгээний тогтсон хэв маягийн тод баталгаа юм.

1.2. Хэл, сэтгэхүйн нэгдэлт чанар

Хэл бол уран зохиолын хамгийн чухал элемент мөн. Хүн төрөлхтний сэтгэхүй нь хэлээр илрэн гарч байдаг. “Хэл бол нэг зүйлийн соёлын загвар мөн” (张文勋, 1998, х.226) бөгөөд тэр нь нэг зүйлийн соёлын үзэгдэл болсны хувьд үндэстэн, газар орны онцлог, үндэстний өвөрмөц сэтгэхүйн хэлбэр ба гоо сайхны шийдэл, үнэт зүйлсийг харуулдаг. Уран зохиолоос тухайн үндэстнийхээ гадна бусад соёлын нөлөөлөл, харь үндэстний сэтгэхүйн онцлог, гоо сайхны таашаал, амьдралын хэв маяг, хүмүүн байгалийн харилцан хамаарал зэрэг олон зүйлийг харж болдог. XX зууны Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиол нь эртнээс уг Монгол хэлээрээ зохиогдож ирснээс улбаалан зохиол бүтээлд илэрч байгаа сэтгэхүйн онцлог, сэтгэлгээний арга, гоо зүйн таашаал зэрэг нь цөм “монгол” ахуйгаа шингээсэн байдаг. Иймд хэл бол соёлыг илэрхийлэх нэгэн том хэрэглэгдэхүүн мөн гэдэг нь тодорхой байдаг. Хэдийгээр салж бутраад гурван зуу гаруй жилийн нүүр үзэж хэл аялгууны, ахуй заншлын хувьд хувьсал гарсан боловч хэл сэтгэхүйн уламжлал, хэв заншлаа

хадгалж ирснээрээ” (Сугар Ү,1999, х.29) Халх, Өвөрмонгол, Ойрдын уран зохиолын өнгө аяс ижил тал ихтэй байдаг нь өнөөгийн хөгжлөөс нь тодорхой харагддаг.

1.3. Нийгэм, түүхийн хөгжлийн ижил шинж

XX зууны монгол соёлд хувьслыг авчирсан чухал хүчин зүйл бол “нийгэм журмын соёл” болно. Халх Монголчууд XX зууны хориод оны эхээр ардын хувьсгалын ялалтыг тэмцэн олж, нийгэм журмын замаар алхсан бол Өвөрмонгол, Ойрд Монголчууд нь хагас зуун жилийн тэмцлийн хүчээр эв хамт намын удирдлага доор 1940-өөд оны сүүлчээр нийгэм журмын замд оржээ. XX зууны эхээр үүсэн энэхүү дэлхийг хамарсан их хувьсгал нь Ойрд, Өвөрмонголоор зогсохгүй дундад улсын нийгмийн дотоод бүтцэд ихээхэн өөрчлөлт оруулж, соёлын хувьсгалд онцгой нөлөөлжээ. Халх, Өвөрмонгол, Ойрадын соёл түүхийн хөгжлийг бүхэлд нь ажиглахад цөм феодалын байгууллагаас социалист хувьсгалын шатанд шилжсэнээр аж ахуйн хувьд эргэлт гарч хувийн өмчлөлөөс нийтийн өмчлөлд шилжин, эд материалын болон оюуны соёлын хөгжлийн хэв маяг нь хэдэн зуун жилээр уламжлан ирсэн монгол соёлд шинэ шинэ агуулгыг бий болгож, соёлын томоохон хувьслыг бий болгожээ. Иймд энэхүү нийгмийн түүхэн хувьслыг бүгд дайрч гарсан нийтлэг шинжээрээ Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолд “ардчилсан үзэл”, “нийгэм журамт уран зохиол” агуулга нэг бүрчлэн шингэсэн байдгаараа эдгээр уран зохиолуудын ижил төстэй талыг батлан харуулж байдаг. Иймээс XX зууны утга, уран зохиолын бичлэгийн хэв маяг агуулгын онцлогоос нийт Монголчуудын нийгмийн хөгжлийн түүхийн өнгө төрх харагддаг.

Хоёр. Халх, Өвөрмонгол, Ойрадын уран зохиолын соёлын өвөрмөц хандлага

2.1. Түүх соёлын талаас

“Соёл нь тасралтгүй хувирч хөгжиж байдаг нийгмийн тусгал мөн.” (张文勋 , 1998, х.150) Энэхүү тасралтгүй хөдөлгөөн хийгээд хувиралтын явцыг хүмүүс “Соёлын хувьсал” (张文勋 , 1998, х. 176) хэмээгддэг. Энэхүү үзэл санааны ёсоор соёлын хөгжил нь зайлшгүй байх ёстой түгээмэл жам ёс мөн бөгөөд нийгмийн амьдралын байнгын хөдөлгөөний үр дүн болно. XX зуунд Монголын соёлын хүрээнд Халх, Өвөрмонгол, Ойрад, Буриад, Халимагийн гэх мэт уран зохиолын чиглэлүүд бий болсон нь нийгмийн хөгжил хувьслын бодит үр дүн гэж хэлж болно. Жишээлбэл, Ойрад нь “XIV зууны үед Ази, Европыг эзэлсэн Монголын дөрвөн хаант улс мөхсөний сүүлээр Ойрад Монголчууд, Ойрад хаант улс, Монгол-Ойрдын Холбоот улс,

Зүүнгар хаант улсыг тус тус байгуулахдаа газар орон сэлгэн нүүдэллэж, Монгол орон болон Төв Азийн газар нутгийг дахин нэгтгэсэн түүхтэй билээ. Гэвч энэхүү дайн байлдаант цагаар тархай бутархай аймгуудын холбоог байгуулан нэгдмэл чанараа хадгалж ирсэн ч гэлээ мөн тэр хэмжээгээр олноор хүйс тэмтрэгдэн, мөн бусад үндэстэнд уусан байснаараа өвөрмөц түүхтэй баялаг ард түмэн билээ”(Сугар, 1999,х.28). Энэ бүх үйл явдал нь Ойрдын соёл түүхийн өвөрмөц шинжийг бүрдүүлж, Ойрад уран зохиолын агуулга сэдвийг өргөжүүлэн, үндэстний ухамсрыг гүнзгийрүүлсэн юм.

1921 онд Монгол улсад ардын хувьсгал ялж, нийгэм түүхийн тогтолцоонд шинэ эргэлт гарчээ. Уран зохиолд хувьсгалын шинэ агуулга сэдэв нэвтрэхийн хамт ард олон уран зохиолын гол дүрслэгдэхүүн болж соёл урлагийн голлох төлөөлөгч болсон байдаг. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хэмжээнд XX зууны хориод оноос эхлэн ардыг гэгээрүүлэх бодлогыг дагалдан уран зохиол туурвих, сонирхох хүмүүсийн тоо олшрон соёл урлагийн хөгжилд томоохон байр суурь эзлэх болсон. Ялангуяа Зөвлөлтийн соёл урлагийн нөлөөгөөр театрын урлаг хөгжиж, уран зохиолын төрлийг баяжуулсан байна.

Шинэ үеийн уран зохиол нь Монголд XX зууны хориод оноос эхлэн эрчимтэй хөгжиж ирсэн бол Өвөр Монгол хийгээд Ойрадад 1940-өөд оны сүүлчээс бий болж хөгжлийн чиг хандлага нь тогтсон байна. Гэхдээ “Монголын уран зохиол нь :

1. 1921-1940 оны ардчилсан хувьсгалын уран зохиол.
2. 1940- 1960 оны нийгэм журамт хувьсгал буюу бүтээн байгуулалтын үеийн уран зохиол.
3. 1960-1980 оны нийгэм журмын үеийн уран зохиол”(Буяндэгжрэх, 1995, х.1-80) зэрэг хэд хэдэн шатлалтайгаар өрнөсөн бол Өвөрмонгол, Ойрад уран зохиол нь «1919-1949 оны ардчилсан уран зохиол», 1949-1966 оны нийгэм журамт хувьсгал ба нийгэм журамт бүтээн байгуулалтын үеийн уран зохиол» (арван долоон жилийн уран зохиол гэдэг), 1966-1976 оны соёлын их хувьсгалын үеийн уран зохиол, 1976 оноос хойших шинэ эриний уран зохиол” зэрэг үе шатыг дамжсан байдаг. Энэ нь хэдийгээр тухайн улс орны нийгмийн хувьсал, улс төрийн бодит хэрэгцээ шаардлагыг дагалдан бий болсон ч нөгөө талаар уран зохиол нь улс орны нийгмийн хувирал хөгжилтэй салшгүй холбоотой хөгжиж ирсэн гэдгийг харуулж байгаа юм.

Мөн XX зууны монгол уран зохиолыг ажиглахад 1940-өөд оноос Монголд кирил үсгээр зохиол бүтээл туурвиж байсан бол Ойрдод тод үсгээр, Өвөр монголд худам монголоор зохиол бүтээлээ туурвиж байжээ. Энэхүү үсэг бичгийн

ялгаа их, бага хэмжээгээр уран зохиолын хөгжилд онцгой нөлөөлсөн нь хэл авианы онцлог шинж, үгсийн сангийн онцлогоос хамааралтай байна. Кирил үсэг нь халх аман аялгуу дээр суурилан зохиогдсоноороо уран зохиолын хэл найруулгад халх аман ярианы нөлөө нэлээд туссан байдаг. Харин Өвөр монголд хуучин монгол үсгийн язгуур уламжлалын өв онцлог түлхүү байхын зэрэгцээ хятад соёлын нөлөөлөл доорх хэл, сэтгэхүйн онцлог илэрдэг. Энэ бүхэн нь уран зохиолд нутгийн аялгууны хэл хэллэг, зан заншлын онцлогийг бий болгож, сэтгэлгээний ялгарлыг бий болгосон байна.

2.2. Сэтгэлгээний талаас

Түүх, соёлын онцлог нь газар орны соёл, сэтгэлгээ, зан заншил, өв уламжлалын шинжийг бий болгодог байна. Тухайлбал, Ойрад Монголчууд эртнээс нааш торгоны замын дагуух нутаг орноор оршин амьдарч ирсэн болохоор өрнө, дорнын соёлын нөлөөг шууд хүртэж өөрийнхөө өвөрмөц заншлыг бүрдүүлсэн байдаг. Түүнчлэн Ойрад Монголчууд нь урт удаан хугацааны турш Уйгар, Казах, Хиргис, Төвд, Огус, Хятад зэрэг олон үндэстэн ястантай холилдон амьдарч ирэх явцдаа зан заншил, соёлын нөлөөг зохих хэмжээгээр байдгаараа бусад монголчуудаасаа ялгарч байхын сацуу эртний зан заншлаа тэр хэвээр нь уламжлан хадгалж өнөөг хүрч ирсэн нь шинэ үеийн уран зохиолд олон талаар нөлөөлж иржээ. Ойрад нутагт үлгэр тууль, ерөөл магтаал, оньсого таавар, дуу холбоо тэргүүтэн “онгон төрх”-өөрөө хадгалагдаж байна. Энэхүү аман зохиолын хөрсөн дээр ойрад уран зохиол цэцэглэн хөгжжээ.

Өвөр монгол оронд Хорчины үлгэрт дуу, Сайчунгийн сэхээрлийн шинж бүхий шүлэг зохиол, ялангуяа “Шилийн сайн эр”-ийн тухай туужийн бүтээл, хорчин уран зохиол зэрэг уран зохиолын төрлүүд бий болсон явдал нь XX зууны Өвөр монгол орны ард түмний сэтгэлгээний өвөрмөц онцлогийн тод илрэл юм. Хорчин уран зохиолын бий болсон түүхэн үзэгдлийг ажиглахад, баатарлаг туульс хайлах хорчин нутгийн өвөрмөц онцлог бүхий дуулах урлагтай уялдан үүний уламжлалын суурин дээр бүрэлдэн бий болжээ. Нөгөө талаар хорчин нутаг нь хятад соёлын нөлөө ихээр нэвтэрч, газар тариаланг түлхүү хөгжүүлэх болсноор нүүдэлчин ахуйн соёлоос хөндийрч амьдралын хэв заншилд багагүй хувиралт гарчээ. Хүмүүн соёлын энэхүү хувьсал нь хорчин нутгийн өвөрмөц онцлог бүхий соёл, сэтгэцийн онцлогийг бий болгосон юм. Энэ бүхэн нь хорчин уран зохиолын хөгжилд нөлөөлсөн байна.

Монголчуудардын хувьсгалтай золгосноор Зөвлөлт Холбоот Улс (тухайн үеийн нэрээр)-аар дамжин өрнө дахины соёл урлагийн нөлөөг

шууд хүртсэн байдаг нь уран зохиолын агуулгад тусгалаа олжээ. Гадаадын улс орнуудтай чөлөөтэй харилцааг бий болгосноор ард түмний амьдрал заншил, соёлын сэтгэлгээнд өрнө дахины нөлөө ихээр нэвтэрч, дэлхийн сонгодог зохиолуудтай эрт танилцаж уран зохиолын хэв маяг өндөр төвшинд хүрсэн байна. Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен нарын зэрэг дэлхийд алдартай эрдэмтэн зохиолчид төрөн гарч “Тунгалаг тамир”, “Миний нутаг”, “Учиртай гурван толгой”, “Үүрийн туяа” зэрэг сонгодог бүтээлүүд туурвигдсан нь монголчуудын соёл, сэтгэлгээнд шинэ дэвшилтэт үзэл орж ирсний баталгаа юм.

2.3. Газар зүйн талаас

Газар зүйн хувиралт нь соёлын хувьслын үндсэн хөдөлгөх хүчин мөн гэх үзлийн гол төлөөлөгч бол Германы Ф.Ратзел болно. Тэрээр “Газар шороо ба амьдрал” номдоо байгалийн орчин тойрон ба соёлын хөгжлийн харьцааг тусгайлан судалж, “байгаль газар зүйн орчин тойрон нь соёлын шинж чанарыг тогтоохоор барахгүй соёлын хэлбэр ба агуулгыг илэрхийлж байдаг. Улс төрийн том жижиг бүлгэм, нийгмийн зохион байгуулалтын хэлбэр, ард иргэдийн зориг санаан бүгдэд нь газар зүйн байрлал нөлөөлж байдаг. Гадаад ертөнц хувирвал нийгмийн соёл дагалдан хувьсдаг” (司马云杰, 2001, х. 322) хэмээн үзсэн байна. Гадаад ертөнц нь үндэстний соёл бий болж бүрэлдэх, хөгжин хувирахад шийдвэрлэх чанар, голлох үүрэгтэй байдаг. Монголчуудын нүүдлийн мал аж ахуйн соёл нь монголын өндөрлөгийн уур амьсгал, газар зүйн онцлогоос төрөн гарсан юм. Нүүдлийн мал аж ахуйн соёл нь эх байгальтайгаа зохицсон нарийн уялдаа холбоотой байдаг. Монголчуудын соёлын сэтгэлгээнд эх байгалиа шүтэх, байгалийг амьдралын утга чанартай холбон үзэх, байгальтайгаа зохицон орших, хайрлан хамгаалах ухамсар гүн гүнзгий шингэсэн байдаг.

Эх дэлхийн тухай сэдэв нь монголын уран зохиолын мөнхийн сэдвийн нэг болсон бөгөөд байгаль дэлхийн шүтлэг нь уран зохиолд өвөрмөц өнгө төрхийг авчирсан байдаг. Тухайлбал, Өвөр монголын баруун орны зохиолчдын бүтээлд говийн өндөрлөгийн амьдрал заншил, орчин ахуй илэрдэг бол хорчин уран зохиолд газар тариалан болон мал аж ахуйн хосолмол орны байгаль ахуй дүрслэгддэг. Халх уран зохиолд онгон дагшнаараа байгаа байгалийн төрхийг илтгэсэн “Миний нутаг”, “Тэхийн зогсоол” мэтийн уянгалал байдаг бол ойрад уран зохиолд Тэнгэр уул, цэцэгт цайдмын өнгө үзэмж илрэхээс гадна хөрш зэргэлдээ үндэстний соёлын нөлөөлөл туссан байдаг. Энэ нь тэрхүү соёлын хүрээлэлд оршин амьдрах ард олны, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг улам тод томруун болгодог.

2.4. Бусад үндэстний соёлын нөлөөллийн талаас

Аливаа үндэстний соёл нь хөгжлийн явцдаа хөрш, гадаад орны соёлтой нөхцөлдөн оршдог нь соёлын хөгжлийн жам хууль болно. XX зуунд Монгол орон ардын хувьсгалын ялалтыг олж, Зөвлөлтийн туршлагаар улс орноо хөгжүүлэх замдаа тууштай орж, улс орны бүтээн байгуулалтад чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Зөвлөлт, өрнө дахины соёлын нөлөө монголд нэвтэрснээр урлаг, утга зохиол төдийгүй амьдрал ахуйн хэв заншилд олон арван өөрчлөлт шинэчлэлийг үзүүлсэн байдаг. Тухайлбал, театр урлаг, шаталсан шүлэг, сэтгэхүйн өгүүллэг, шог өгүүллэг гэх мэт олон төрлөөр салбарлан хөгжих үүд хаалга нээгдсэн байна.

Өвөр монголын ихэнх Монголчууд Хятад үндэстэнтэй хаяа дэрлэн холилдон сууж, амьдралын хэв маяг заншлын нөлөөнд автаад зогсохгүй сургууль соёл, ажиллах орчин, төрийн ажил хэрэг бүгд хятад үг, хэл, үсэг бичиг хэрэглэгддэг болсноос Хятад соёл ард түмний сэтгэлгээнд гүн гүнзгий нөлөөлсөн нь хорчин уран зохиолын хэв маягт бодит тусгалаа олсон байдаг. Иймээс хятад соёл, зан заншил нь Өвөр монголын ахуй амьдралд нөлөөлөөд зогсохгүй бүр цаашилбал сэтгэхүйн арга хэлбэрт цоо шинэ хувирлыг бий болгосон нь Өвөр монгол уран зохиол их төлөв хятад үндэстний урлаг, уран сайхны хөгжлийн явцыг дагалдан ирснээс харж болно. Тухайлбал, “Арван долоон жилийн уран зохиол”, “Соёлын их хувьсгалын үеийн уран зохиол”, “Шинэ эриний уран зохиол” зэргийг дурдаж болох бөгөөд эдгээрээс хятад уран зохиолын түүхэн хөгжилтэй хөл нийлүүлж ирснийг харж болох юм.

Ойрад уран зохиол нь үндсэндээ Өвөр монгол уран зохиолын хөгжилтэй зэрэгцэн хөгжиж ирсэн боловч урт удаан хугацаанд Уйгар, Казах, Хиргис, Төвд, Огус, Хятад зэрэг олон үндэстэнтэй холилдон амьдарч ирсэн онцлогтойгоороо тэдгээр үндэстнийхээ зан заншил, соёлын нөлөөг ихээхэн хүртсэн байдаг нь бусад Монголчуудаас ялгарах хүчин зүйл бөгөөд энэ нь ч уран зохиолын элементэд тусгалаа олсон байдаг.

Дүгнэлт

Тус судалгааны үр дүнгээс үзвэл дараах дүгнэлтийг хийж болох юм. Үүнд:

-Эрт цагаас нэгэн язгуур хөрснөөс соёлон хөгжсөн Монгол уран зохиолын хөгжил нь нийгэм-эдийн засаг, улс төр, түүхийн хүчин зүйлүүдийн улмаас XX зууны үе гэхэд наанадаж гурван том урсгал болон харилцан адилгүй онцлогтойгоор хөгжин хувьсах болжээ.

-Хэдийгээр XX зуунаас өөр өөр онцлогтойгоор хөгжих болсон боловч тэдгээр ялга

бүхий хөгжлийн зүй тогтол нь хэд хэдэн хүчин зүйлээр нийтлэг байдаг. Энэ хүрээнд соёл, хэл сэтгэхүй, нийгэм-түүхийн гэсэн гурван гол хүчин зүйлийг онцгойлон дурдах хэрэгтэй.

-Халх, Өвөр Монгол, Ойрадын уран зохиол нь түүх-соёл, сэтгэлгээ, бусад үндэстний соёлын нөлөөлөл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан харилцан адилгүй өвөрмөц онцлогтойгоор ялгаран хөгжсөн байна.

-Цаашид Монгол туургатны бусад төлөөлөл болох Буриад, Халимаг, Тува зэрэг улсуудын уран зохиолын онцлог ялгаа, нийтлэг тал хандлагыг өргөн далайцтайгаар судлах нь чухал юм. Ингэснээр Монгол соёлын хувирал хөгжлийн зүй тогтлыг илрүүлэн гаргахаас гадна түүний хүрээнд уран зохиолоор дамжуулан илэрхийлэгддэг үзэл санааны нэгдмэл шинжийг ч томъёолон дүгнэх боломжтой билээ.

Ашигласан материал

- Буяндэгжрэх, Бай Ган. (1995). Монгол улсын орчин үеийн утга зохиолын товчоон. Хөх хот: Өвөр монголын бага чууд хүүхдийн хэвлэлийн хороо.,
- Сугар, Ү., Дамбапэлжид, П. (1999). Ойрад монголын орчин үеийн уран зохиолын түүх. Хөх хот: Шинжааны ардын хэвлэлийн хороо.,
- Хасгоо. (1998). Эртний монголын яруу найргийн үүсэл хөгжлийн тойм. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.,
- Цэдэв, Д. (1986). Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.,
- 张文勋, 施惟达, 张胜冰, 黄泽. (1998). 北京: 《民族文化学》 中国社会科学出版社.
- 司马云杰. (2001). 北京市: 《社会文化学》 中国社会科学出版社.